

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг: Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Өвөрхангай аймаг дахь магадлан итгэмжлэгдсэн Политехник коллеж / цаашид “сургууль” гэх/-ийн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Сургууль нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа энэхүү нийтлэг журам болон Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг удирдлага болгоно.

Хоёр. Дотоод хяналт шалгалтын зарчим, зорилго, хамрах хүрээ

- 2.1. Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.
- 2.2. Дотоод хяналт шалгалтын зорилго нь Монгол улсын хууль, тогтоомж, бусад эрхзүйн актын болон сургуулийн захирлын тушаал, шийдвэр, сургуулийн дүрэм, журмын хэрэгжилт, сургалтын үйл ажиллагаа, хичээлийн явц, сахилга дэг журам, сургуулийн санхүү аж ахуйн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, зарцуулалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, сургуулийн дотоод, гадаад үйл ажиллагаа зэрэг сургуулийн бүхий л үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөрчил дутагдал, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.
- 2.3. Сургуулийн захирлын тушаалаар дотоод хяналт шалгалтын орон тооны бус байнгын баг ажиллана.
- 2.4. Дотоод хяналтын баг, ажилтан нь хяналт шалгалтыг удирдах албан тушаалтнаар батлуулсан удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, сургуулийн үйл ажиллагааг бүрэн хамруулна.

Гурав. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах баг, ажилтан, түүний эрх үүрэг

- 3.1. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг сургуулийн дотоод хяналтын баг, дотоод аудит, хяналт шинжилгээ хариуцсан ажилтан гүйцэтгэнэ.
- 3.2. Дотоод хяналт шалгалтын баг, ажилтан нь сургуулийн удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна.
- 3.3. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь сургуулийн эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна.
- 3.4. Дотоод хяналт шалгалтын баг, ажилтан нь сургуулийн үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.
- 3.5. Дотоод хяналт шалгалтын баг, ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаарх мэдээллийг сургуулийн удирдлагуудад танилцуулж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээнэ.
- 3.6. Дотоод хяналт шалгалтын баг, ажилтан нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна.
 - 3.6.1. Зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж,

- дүнг тайлагнах;
- 3.6.2. Хяналт шалгалт явуулахдаа холбогдох албан тушаалтнуудтай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;
 - 3.6.3. Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;
 - 3.6.4. Шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;
 - 3.6.5. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг албан хаагчдад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах;
 - 3.6.6. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
 - 3.6.7. Холбогдох дүрэм, журам, сургуулийн стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах;
 - 3.6.8. Дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах;
 - 3.6.9. Сургуулийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаарх мэдээллээр удирдлагыг хангах;
 - 3.6.10. Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;
 - 3.6.11. Дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх.
- 3.7. Энэхүү журмын 3.6-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод хяналт шалгалтын баг, ажилтанд аливаа дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Дөрөв. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл

- 4.1. Хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд тавих хяналт шалгалт
 - 4.1.1. Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Багш хөгжлийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухайн хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдах, худалдан авах тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай, Статистикийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсрол, бодлого зохицуулалтын газрын хүрээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандарт, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журам, стандарт, норм, нормативын хэрэгжилт сургуулийн хэмжээнд хэрхэн биелэгдэж байгаад хяналт-шинжилгээ хийж, санал дүгнэлт гаргах, хэрэгжилтийг хангуулах;
- 4.1.2. Сургуулийн дотоод үйл ажиллагаа, төлөвлөлт, менежмент, мөрдөгдөж байгаа дүрэм, журмын биелэлт, захирлын тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж, хэрэгжилтийг хангуулах;
- 4.1.3. Хамтын гэрээ, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавьж, дүгнэлт гаргах;
- 4.2. Сургалтын үйл ажиллагаанд тавих хяналт
- 4.2.1. Сургалтын албаны менежер, арга зүйч нарын сургалтын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангуулах
- 4.2.2. Хичээлийн жилийн төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл, сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаа стандартын дагуу явагдаж буй байдалд
- 4.2.3. Багш нар сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлсөн байдал, хичээлийн хуваарь, хичээлийн үргэлжлэх хугацааг мөрдүүлж ажиллуулах
- 4.2.4. Багшийн ур чадвар, заах арга зүй, ажлын норм норматив, анги дүүргэлт, ажлын ачаалал, цагийн тооцооны байдалд тавих хяналт
- 4.2.5. Суралцагчдын хяналтын тооллогын мэдээг батлагдсан маягтын дагуу үнэн зөв гаргасан байдалд тавих хяналт
- 4.2.6. Суралцагчийг элсэн суралцах үеэс эхлэн, мэргэжлийн чиглэлийн дагуу ажлын байртай болгох бодлого, арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан байдалд тавих хяналт
- 4.2.7. Нийгмийн ажилтны судалгаан дээр үндэслэн суралцагчийн хүмүүжил төлөвшилд хяналт тавих
- 4.2.8. Анги удирдсан багшийн үйл ажиллагаанд хяналт тавих
- 4.2.9. Хичээлээс гадуур сургалтын ажил нь суралцагчийг танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авьяас сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэгдэж байгаа байдалд хяналт тавих
- 4.2.10. Суралцагсад, багш ажилчид, эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийн байдалд тавих хяналт
- 4.2.11. Химийн хортой болон аюултай бодис ашиглах, хадгалах байдалд тавих хяналт
- 4.2.12. Сургалтын тоног төхөөрөмж, дадлагын газруудын нөхцөл байдалд тавих хяналт
- 4.2.13. Ачаа өргөх краны аюулгүй байдлыг хангаж ажиллаж буй эсэхэд
- 4.3. Санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд тавих хяналт
- 4.3.1. Төсвийн төлөвлөлт, хандив тусламж, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, хичээл практикийн зардлын зарцуулалт, төсөв санхүүгийн үйл ажиллагааны тайлан нээлттэй ил тод байгаа байдалд
- 4.3.2. Санхүү нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэлд болон төсвийн зарцуулалтыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байгаа байдалд дүн шинжилгээ хийх
- 4.3.3. Сургуулийн өмч хөрөнгийн тооллого, бүртгэл, хадгалалт, ашиглалт, хамгаалалтыг шалгаж, зөрчил дутагдлыг шуурхай барагдуулах
- 4.3.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд

- 4.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, сургалтын орчны стандартад тавих хяналт шалгалт
 - 4.4.1. Сургалт зохион байгуулж байгаа анги, танхим, кабинет, лаборатори, коридор, биеийн тамирын заал, дотуур байранд тавигдах шаардлага, орчны стандарт болон хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн байдалд
 - 4.4.2. Сургуулийн анги танхим, заал, талбай, цайны газар, номын сан, дотуур байр, дадлагын газар зэрэг орчны ариутгал халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээний байдалд
 - 4.4.3. Багш, суралцагч, ажилтныг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас, хэрэгслээр хангасан байдал
 - 4.4.4. Сургуулийн хэмжээнд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны дүрэм, журам боловсруулан баталж, мөрдөж хэвшсэн байдалд
 - 4.4.5 Аюулгүй ажиллагааны зааварчилгааг нийт багш, ажилтан, суралцагчид өдөр тутам болон цаг тухайд нь өгч байгаа эсэхэд
 - 4.4.6. Суралцагчдын хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн байдлыг хангаж буйбайдалд
 - 4.4.7. Сургуулийн болон дотуур байрын орчин дахь эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлд
- 4.5. Бусад чиглэлээр тавих хяналт
 - 4.5.1. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөлт, нийгмийн даатгалын дэвтрийн бичилтийн байдалд
 - 4.5.2. Хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, албан тушаалтны хяналт шалгалтын хүрээнд гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих
 - 4.5.3. Байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагааны байдалд
 - 4.5.4. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан хяналт шалгалтын хуудсын дагуу бусад хяналт шалгалтыг зохион байгуулах

Тав. Хариуцлага

- 5.1. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний алан хаагчийн ёс зүйн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомж, сургуулийн дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.
- 5.2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.